

Шарав дайчин нанс, Даги, Төвд гэлэн Бандид цорж зэрэг долоон хүний орчуулсан ном бидэнд олдоод байна.

XVII зууны үеийн монгол даяарт бөө мөргөл зонхилж байв. Хязгаарлагдмал, орон нутгийн чанартай байсан бөө мөргөлтэй шаргуу тэмцэл хийж, Зая бандид «Зурхайн зуун үзэл», «гариг одны тохиол» зэрэг зурхайн ном, «Рашааны зүрхэн найман үет нууц увдисын үндэс» зэрэг анагаах ухааны холбогдолтой зохиол, «олон номын үндсэн үзгийн ялгал», «ёгт нэр, ёгт нэрийн тайлбар» зэрэг хэл бичгийн холбогдолтой зохиол, «мэдээтэй мэдээгүй ялгагч судар буюу үлгэрийн далай», «Эрдэнийн сан Сувашид» зэрэг уран зохиолын ном, «Найман мянган шүлэгт», «Билэг бармидын зэрэг» зэрэг гүн ухааны ном, «Таван сахъяа» буюу «Банзрагч», «Их тонилсоны зүгт дэлгэрүүлэгч» зэрэг бурхан шашны ном орчуулжээ. Зурхай, анагаах ухаан, хэл бичиг, уран зохиол гүн ухаан, бурхан шашны холбогдолтой өдий төдий олон зохиолыг монгол хэлэнд орчуулсан Ойрадын Зая бандидын үйл ажил бол тэр үедээ дэвшилттэй зүйл байв.

Үүгээрээ тэр үеийн Халх долоон хошуу ялангуяа Дөрвөн Ойрадыг орон нутгийн чанартай бөө мөргөлийн явцуу хүрээнээс татан гаргаж Энэтхэг, Төвдийн соёлын өргөн хүрээнд оруулсан учраас Зая бандидыг XVII зууны үеийн монгол дахины соёлын зүтгэлтэн гэж зохих ёсоор үнэлж байгаа юм.

## **ЭНЭТХЭГ, ТӨВД, МОНГОЛЫН УТГА ЗОХИОЛ, ТҮҮХ СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ УЛАМЖЛАЛ**

Л. ХҮРЭЛБААТАР

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн

Монголын уран зохиолын дотор монгол зохиолчдын төвд хэлээр бичсэн олон зохиолыг оруулан судалбал зохино. Гэхдээ төвд хэлээр бичсэн тэдгээр зохиолыг зөвхөн Монголын тухайд салган авч үзэх биш, үүсч хөгжихөд нь нөлөө дууриал болсон Энэтхэг, Төвд зэрэг улс үндэстний зохиол бүтээлтэй холбон судлах хэрэгтэй юм. Ийнхүү судлах нь чухамдаа Энэтхэг, Төвд, Монголын утга зохиолын харьцаа, иргэний болон шашны агуулгатай зохиолын харьцааны асуудлыг ямар нэг талаар хөндөхөд хүргэнэ. Яагаад гэвэл утга зохиолын эл хэлхээ холбоо нь эрт дээр цагаас түүх соёлоор нягт зузаан харилцаатай явж ирсэн Энэтхэг, Төвд, Монголын харилцааны түүхээс үндэс сурвалжтай юм.

Юуны өмнө Энэтхэг, Монголын ном соёлын харилцаа нь өнө холын түүхтэй, эрх ба хожуугийн, дам ба шууд, олон замын харилцаа байсныг тэмдэглэвэл зохино. Энэ тухай академич Ц.Дамдинсүрэн бичихдээ: «Ганга мөрний хөндийгөөс цаст Гимлайн өндөр уулыг давж Монголын тал руу урссан соёлын олон мянган шижим байна»<sup>1</sup> гэжээ. Тэгвэл бид олон үеийн турш Монголд нэвтэрсэн Энэтхэг, Төвдийн гаралтай уран зохиолын баялаг уламжлалыг тэрхүү олон мянган алтан шижмийн» нэ-

гэн хэлхээ гэж үзэж болно. Энэтхэг, Монголын түүх соёлын энэ «алтан шижмүүдийн» анхны хэлхээ холбоог бүр манай эриний өмнөх нэгдэх мянган жилийн сүүлчээс эхлэн ярьж болох бөгөөд Төв Азийн орнууд, түүний дотроос ялангуяа Хотан, Согдоор дамжиж Монголын тал нутагт дэлгэрсэн Бурханы шашны эртний үетэй холбон үзэж болно<sup>2</sup>. Барагцаалбал манай эриний өмнөх нэг дэх мянган жилд Бурханы шашин дэлгэрч, шинжлэх ухааны салаа мөчир бүхнийг шашны номлолтой холбон тайлбар дах болсноос Энэтхэгийн соёлын ололт, шашны сургаал холилдон нийлж Азийн улс орнуудад тархсан байна<sup>3</sup>. Иймд Бурханы шашин, монголд анх нэвтрэн орсон гол зам, цаг үеийг тодосгох нь Энэтхэг, Монголын соёлын харилцааны түүхэн он цагийг тогтооход их чухал юм. Финляндын нэр өндөр гарсан монголч эрдэмтэн Г. И. Рамстедт 1922 онд бичсэн «Уйгур улсын хураангуй түүх» гэдэг номдоо Төвдөөс аль өмнө Энэтхэгийн Бурханы шашин Согдоор дамжин Монголд мандаж байсан тухай өгүүлсэн бол<sup>4</sup>, Зөвлөлтийн эрдэмтэн академич Б. Я. Владимирцов уйгур, монгол хэлэнд байгаа бурханы шашны ихэнх нэр томъёог Согдоор дамжиж, санскритээс орсон үг гэжээ<sup>5</sup>. Г. И. Рамстедт, Б. Я. Владимирцов нарын эл санааг Монголын шашны түүхч Зава-Дамдин (1867—1937) «Хор чойнжүн» (Монголын номын гарлага) буюу «Монголд Бурханы шашин дэлгэрсэн түүх» гэдэг номдоо шууд авч: «Согдын мэргэн багш нар Уйгур хийгээд Монгол нугуудад үсэг бичих, унших ба Бурханы дээд ном зарлиг шастир, сайн зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургав. Тэр цагт уйгур, монгол хүмүүний аймгууд сайн зарлигийг уншихдаа согд бичгийн дээрээс энэтхэг хийгээд өөр өөрсдийн хэл нүүгдийг холимогоор орчуулсан... тэр шалтгаанаар одоо манагаар монголын номын хэл нь энэтхэг, уйгур, монгол холимогоор оршсон болой»<sup>6</sup> гэх мэтээр бичжээ. Зохиогч ялангуяа энэ номынхоо дэлгэрэнгүй тайлбар «Алтан дэвтэр»-т Энэтхэг, Монголын ном соёлын эртний уламжлалт харилцааг тодруулахад чухал ач холбогдол бүхий олон мэдээ баримтыг хятад, төвд сурвалж бичгээс түүвэрлэн орчуулсан байна<sup>7</sup>. Академич Ш. Бира «Алтан дэвтэр»-ийн энэ мэт зарим ололтыг тэмдэглэж «Энэтхэгийн шашин соёлыг Төв Азид дамжуулагчийн үүрэг гүйцэтгэж байсан Хотангаас Монгол нутагт байсан эртний зарим аймгуудын дунд анх дэлгэрсэн тухай зохиогчийн үзэж байсныг ихээхэн зөв санаа» гэж бичсэн байна. Үүнтэй холбогдуулж «Ганжуурын уншлагын эш авсан товъёг» дотор Энэтхэгийн шашин номын эхийг ... Сангасэна тэргүүтэн Кушаны 8 багшаас Кальяанаракшита тэргүүтэн Уйгурын 20 багш, тэднээс Үйба Лосал санжайбум тэргүүтэн Төвдийн багш нар дамжуулан авсан тухай дурдсан байдгийг авч үзүүштэй<sup>8</sup>. Энэ нь Бурханы шашин Монгол нутагт Дорнод Туркестанаас хойт зүгийн говь нутаг руу орж ирсэн тухай Банзарын Доржийн бичсэнтэй бас холбогдоно. Ер нь Дорнод Туркестаныг хүртэлх өргөн уудам нутгийг эзэмшин, манай эриний IV зууны эцсийг хүртэл цэцэглэж байсан «Кушан гүрэн бол Ази тивийн ард түмний дунд эртний Энэтхэгийн болон дунд Азийн соёлын ололтыг дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ». Энэ мэт судалгааны ая дашрамд өгүүлсэн зүйлс хийгээд зарим төвд сурвалжийн мэдээ сэлтийг нийлүүлж үзвэл, Бурханы шашнаар дамжин Монголын тал нутагт дэлгэрсэн Энэтхэгийн соёлын эртний замыг Кушан, Хотан, Согд Уйгур гэж нэгэн адил тэмдэглэж иржээ. Мөн Энэтхэгийн шашин ном Монголд дэлгэрч эхэлсэн үеийг Төвдөд шашин мандахаас их эрт гэж зарим сурвалжид тэмдэглэсэн байдгийг VII зууны үед Төвдүүд бичиг үсэгтэй болж номын эхийг авсан түү-

хийн баримтаар эш болговол түүнээс зэгсэн өмнийн хэрэг болно. Нөгөө талаар V зууны үед Уйгур зэрэг Төв Азийн зарим нүүдэлчин аймаг Согдоос бичиг үсэгтэй болж<sup>9</sup>, энэтхэгээр ном судар уншиж байсан<sup>10</sup> явдлыг түүхийн нилээд үнэнтэй баримт гэж үзвэл, тэдэнтэй нутаг дэвсгэр хөрш зэргэлдээ, түүх соёл ойр дөхөм байсан монгол аймгийг эртний Энэтхэгийн болон Төв Азийн соёл иргэншлээс салангид авч үзэхийн аргагүй. Кушан гүрний үеэс Хотан, Согдоор замнаж ирсэн, Энэтхэгийн соёлын ололт Уйгурын уламжлалаар дамжиж Монголын утга соёлд гүн гүнзгий ул мөрийг үлдээжээ. Монголчуудаас Бурханы шашны номыг уйгураар уншиж, уйгураар орчуулж байсан явдлыг зөвхөн ганц шашны хэмжээнд ойлгож болохгүй, харин Энэтхэгийн соёлын их ололт, Төв Азийн нүүдэлчин аймгуудын соёлтой хамт Монголд нэвтэрч байсан гэж үзвэл зохино. Б. Я. Владимирцов шинжлэн тогтоосноор монгол хэлэнд орсон олон тооны санскрит үг ерөнхийдөө Хотан, Согдын хэлбэрийг хадгалан Уйгурын бичгийн уламжлалаар өнөө үед хүрч ирсэн байхын дээр XIII—XIV зууны үед монголын орчуулагч нарын санскрит, төвд хэлнээс хийсэн орчуулгын зүйлст төвд нэр томъёог авахын оронд хуучин Уйгурын орчуулгын заншлыг дагаж шууд санскрит хэлний нэр томъёо болон Монголчуудын нэгэнт мэддэг болсон уйгур нэр томъёог авч хэрэглэдэг болсон нь ч Энэтхэгийн соёлын уламжлал Уйгураар дамжин Монголд нэвтэрч байсныг илтгэх нэг жишээ юм<sup>11</sup>. Энэтхэгийн соёлын анх эртний уламжлалыг Монголын тал нутагт Согд, Уйгураар дамжин нэвтэрсэн Бурханы шашны түрүү дэлгэрэлтийн үеэс сурвалжтай гэж үздэг бол, түүний хожуугийн боловч хамгийн гол уламжлалыг Төвдөөр дамжин нэвтэрсэн Бурханы шашны дунд (XIII-XIV зуун) ба хожуугийн (XVI зууны П хагасаас хойшхи) дэлгэрэлтийн үеэс авч ярьдаг юм. Тухайлбал, XIII зууны дунд үеэс Монголчууд Энэтхэгийн Бурханы шашныг Төвдөөр дамжуулан авах явцад Төвд, Монголын харилцаанд ном соёлын давхар хэлхээ тогтож<sup>12</sup>, Төвд орон монголчуудын оюун санааны амьдралын гол чухал төв болж эхэлсэн байна. Тэр үеэс санскрит төвд хоёр хэл Монголын номын хэл болж<sup>13</sup>, Монголчуудын оюун санааны амьдралд үлэмж чухал нөлөө үзүүлсэн ажээ. Эртний Энэтхэгийн гүн ухаан, учир шалтгааны ухаан, түүх, яруу найраг, хэл шинжлэл, урлаг, эмнэлэг-эм зүй, одон орон, уран барилгын зэрэг хүн төрөлхтөний мэдлэгийн төрөл бүрийн салбараар туурвисан үлэмж хэмжээний бүтээлтэй монголчуудыг танилцуулахад санскрит хэл төвд хэлнээс дутуугүй Үүргийг гүйцэтгэсэн юм.

Энэтхэгийн арван ухаан гурван аймаг савын номыг санскритээр «Трипитака» («Гурван сав») гэх бөгөөд үүнийг Энэтхэгийн бандид (Таван ухааны эрдэмтэн), Төвдийн лозава (хэлмэрч) нар хамтарч судар, шастир гэдэг хоёр ерөнхий ангилал дагуу Ганжуур (Зарлигийн орчуулга), Данжуур (Шастирын орчуулга) хэмээх хоёр том цоморлиг болгон төвд хэлэнд орчуулжээ. Энэхүү Ганжуур, Данжуурын баялаг утга зохиолоос орчуулах, судлах ажлыг Монголын эрдэмтэн орчуулагчид XIV зууны эхэн үе гэхэд нэгэнт хийж байсан байна.

Нэрт хэлмэрч Чойжи-Одсэр бандид тэргүүтэн хоёр хэлийг өгүүлэгчийн эрхтнүүд Өлзийт (1294—1307) болон Хайсан хөлөг (1304—1311) хааны үеэс «Бодичарияавадра» («Бодисадын явдалд орохуй»), «Банзрагч» («Таван сахьяа»), «Алтан гэрэлт» («Суварнаправхасоттама-сутра») зэрэг Энэтхэгийн шашин, гүн ухааны алдартай номыг төвд, уйгур хэлнээс орчуулжээ<sup>14</sup>. Монголын орчуулагчид Бурханы шашны зохиолыг орчуулах ажлыг Уйгур, Төвдийн эрдэмтэн лам нарын удирдлагаар хийж

байсан нь эртнээс наашид Уйгур, Төвдүүд Энэтхэгийн соёлыг Монголын тал нутагт дамжуулах хэрэгт их үүрэгтэй байсны гэрч юм.

Тэр үеийн дуун хөрвүүлэгч гүүш нар их төлөв санскрит төвд хоёр хэлний орчуулагчид байсан бөгөөд академич Б. Ринчений бичсэнээр «Их Монгол гүрний үед монголоор «Улсын багш» гэдэг хятадын «гүе-ши» гэдгээс зээлдсэн «гүүш» хэмээх хүндэт цолыг Монголын сонгодог хоёр хэл- санскрит, төвдийг гарамгай сурсан эрдэмтэнд өгч байсан бөгөөд хожим тэрхүү санскрит төвд хоёр хэлний орчуулагч гүүшид хоёр хэлийг өгүүлэгч «тал аялгуут» хэмээх чимгийг нэмсэн байна»<sup>15</sup>.

Чойжи-Одсэр бандид, Тарнич тойн Соном-Гара нарын нэрэнд орсон **бандид, тарнич** гэдэг санскрит үг нь энэтхэг хэл, Энэтхэгийн эрдэм ухаанд ихээхэн боловсорсон хүнд хэрэглэж байсан эрдмийн цол чимэг юм. Үүнтэй холбогдуулж Монголын мэргэдээс Энэтхэгт очиж, ухааны таван оронд мэргэжээд «Махабандид» (Таван ухааны их эрдэмтэн) гэдэг эрдмийн дээд цолыг хүртэж байсан тухай зарим төвд сурвалжийн мэдээг дурдаж болно<sup>16</sup>. Бас «Монголын хаад орчуулагч нарт туслахын тулд Энэтхэг орноос санскрит хэлний мэргэжилтэн нарыг урин ирүүлж, тэд монголчуудын суралцахад зориулж санскрит хэлний зүй, сурах бичгийг зохиож байсан байна. Энэтхэгийн «азар» хэмээх мэргэн багш нарын дотор Бахаа бандид (Чулуун хуруут азар) гэдэг их бага хоёр эрдэмтэн Монголын хааны ордонд санскрит хэлийг зааж «Шидэт хүүрийн үлгэр» тэргүүтэн иргэний гайхамшигт зохиолыг дэлгэрүүлж байсан байна<sup>17</sup>. Ганжуур, Данжуураар уламжлан ирсэн Энэтхэгийн эрдэм ухааныг санскрит төвд хоёр хэлээр судалж, зохиол бүтээлээ төвд монгол хэлээр бичиж байсан, Монголын эрдэмтэн зохиолчдыг бас тэр үеэс эхлэн ярьж болно. XIV зууны үед Чойжи-Одсэр бандид «Бурханы арван хоёр зохионгуй» гэдэг номыг төвд хэлээр бичсэний нь Есөнтөмөр хааны үед (1324—1327) Шаравсэнгэ хэлмэрч монгол хэлнээ орчуулжээ<sup>18</sup>. Мөн XII—XV зуу ны үед бичсэн монгол хэл зүйн бүтээлүүдээс эртний Энэтхэгийн хэл зүйн нөлөөг төвөггүй олж болно<sup>19</sup>. Дандины «Кавьяадарша» хэмээх, төвдөөр «Нян-аг мэ-лон», монголоор «Зохист аялгууны толь» нь тэр үеийн монгол зохиолчдын дотор багагүй дэлгэрч, түүний чимгийн зарчмаар бичсэн тахилын болон төгсгөлийн шүлэг олон гарчээ.

Гагцхүү харамсалтай нь VIII—XI зууны үеэс уламжлалтай, бичиг соёлын асар их өв дурсгал Төв Азийн нүүдэлчин монголчуудын ахуй нөхцөлийн эрхээр өнөө бидэнд бүрэн бүтэн хүрч ирсэнгүй.

Харин XVI зууны хоёрдугаар хагасаас эхлэн, Монголд Төвдийн Гэлүгбийн ёсныхны үндэслэсэн, Бурханы шашны өөр нэг шинэ хэлбэр шарын шашны улам хүчтэй дэлгэрэх болсноос хойш Энэтхэг, Төвдийн соёлын хүрээнд монголчуудын нийлэн нэгдэх явц улам түргэссэн байна. Энэ явц Монгол оронд Манжийн дарлал ноёрхож байсан бүхэл үеийн туршид тасалдаагүйгээр үл барам, харин ч үлэмж ихсэж, Монголын нийгмийн амьдралын оюун санааны хүрээнд Хятадын нөлөө нэвтрэхийг хааж сулруулах чухал хүчин зүйл болж байв. Иймээс ч Монголын төвд хэлт утга зохиол буй болж хөгжихөд шууд нөлөөлсөн Төвдийн оюун санааны амьдрал хийгээд төвд хэлний асар их соёлыг өмнөх судлаачид нэгэнт үнэлэн тэмдэглэсэн билээ<sup>20</sup>. Угтаа монголчуудын, төвд хэлнээс ном судар орчуулж, уул хэлээр зохиол бүтээл бичиж эхэлсэн уламжлалыг XIV зуунаас эхэлж үзэх боловч монголчуудын төвд хэлт утга зохиолын их үйлс идэвхийлэн өрнөх болсон үеийг XVII зуунаас авч ярьдаг юм.

Тэр үеэс хойш төвд хэлээр зохиолоо бичдэг монголын хэдэн зуун эрдэмтэн сэхээтэн бий болж, төвд хэлт бүхэл бүтэн утга зохиолыг буй

болгожээ<sup>21</sup>. Гандантэгчинлин хийдийн хамба лам агсаң С. Гомбожав төвд хэлээр зохиолоо бичиж байсан 200 гаруй монгол зохиолчийн нэрийг гаргахдаа арав хорин боть сүнбүмтэй лам нарыг дав дээр бүртгэн оруулсан байна<sup>22</sup>. Гэтэл бүтэн сүнбүм (Буман зарлиг буюу бүрэн эмхтгэл) бүрдээгүй боловч нилээн хэдэн зохиол бичсэн, тэдгээр нь бидний үед уламжлан хүрч ирээгүй хичнээн монгол зохиолч цаана нь үлдэж байгааг өнөө хир тоолж гаргана гэхэд бэрх байгаа юм. Монголчуудын дотроос төвд хэлээр зохиолоо бичиж олон боть сүнбүм болгоод зөвхөн хошуу хүрээ тэдийдээ бус, Бээжин, Лавран. Гүнбүм, Амдо зэрэг Хятад, Төвдийн том том барын газар хэвд бүтээлгэж, зарим зохиолоороо Төвдийн мэргэчүүлд гайхагдаж байсан зохиолч, гүн ухаантан олон гарчээ. Мөн Монголын зарим эрдэмтэн Энэтхэг, Төвдийн мэргэчүүлийн хийсэн их бага арван ухааны зохиол бүтээлийг дахин задлан тайлбарлаж, зарим зүйл дээр санал зөрж харилцан шүүмжлэлцэж байжээ. Жишээ нь, Жанжа Ролбидоржийн (1717-1786) зохиосон «Эх юугаан танин барих»<sup>23</sup> нэрт гүн ухааны шүлэглэсэн зохиолд хийсэн Төвдийн эрдэмтэн Радэн номун хан Ишдамба равжайгийн (XIX зууны) тайлбарыг<sup>24</sup> Амдогийн Балман цан Гончигжал дан (1764-1853) буруушаан шүүмжилсэн зохиолыг<sup>25</sup> бичжээ. Түүний нь хариуд Монголын эрдэмтэн Агванхайдав (1779—1838) «Хориглон шүүмжилсний хариу-галын оньсон хүрд»<sup>26</sup> гэдэг няцаалт зохиол бичсэн байна.

Энэ бол Монголчуудын оюуны соёл хир өндөр байсныг харуулах баримт мөн. Монголчууд Энэтхэг, Төвдийн их бага арван ухааныг хамран зохиол бүтээлээ туурвиж байсны дотор дуун ухааны аймагт ялгагдах санскрит хэл шинжлэл, ёгт үгс, яруу найраг, шүлэглэл зүйн онол бодрол, түүний тайлбар болон шууд уран зохиолын дурсгал болох үлэмж олон бүтээлийг зохиосон байна. Тэдгээрийн нэгэнд монгол зохиолчдын төвдөөр бичсэн иргэний чиглэлтэй сургаалын шүлгүүдийг оруулан хэлэлцэх ёстой. Тийм сургаалын шүлгийг монгол лам нарын сүнбүмээс шүүхэд хэдэн зуугаараа бий. Зарим нь «Сургаалын аймаг»<sup>27</sup> «Гүр дууллыг нэгэн зүг дор байгуулсан»<sup>28</sup> нэртэйгээр сургаалын чиглэлтэй олон зохиолыг эмхтгэн нийлүүлж сүнбүмдээ оруулсан байна. Бас ямар нэг зохиолчийн сүнбүмд ороогүй, зохиогчийн нэр нь ч тодорхойгүй, гар дамжин хуулагдсаар явдаг олон сургаал байна. Энд нэг зүйлийг тэмдэглэхэд бидний авч үзэх буй сургаалууд нь утга агуулгын хувьд төдийлөн цэвэр шашин номын бус, харин иргэний чиглэлтэй хосолсон, тэр ч байтугай зарим нь иргэний тал руу илэрхий хэлбийсэн байдаг тул ихэс лам нарын сүнбүмийн сүүлчийн боть буюу эцсийн хэдэн хуудсанд хавчуулагдан орсон нь элбэг тохиолдоно.

Гэвч иргэний чиглэлтэй эдгээр сургаалыг эх сүнбүмээс нь тусгайд сугалан авч, бичмэл, дармал, том жижиг олон янзаар хуулан дэлгэрүүлж, төвдтэй нь төвдөөр үзэж, төвдгүй нь монгол орчуулгаар уншиж, төвд Монгол бичиггүй нь аман орчуулгаар тогтоон цээжилж олон түмний жинхэнэ гарын ном болж байсан байна. Үүний гол учир нь зөв аж төрөхөд хэрэгтэй сургаалыг ертөнцийн хүнд тохируулж өгүүлсэн байдаг оршино. Иймд Бурханы шашны хоосон чанарын үзэл, бодь мөрийг тайлбарласан хорь гучин боть номоос илүүгээр олон түмний санаа сэтгэлд ойр

дотно нийцэж байсан иргэний агуулгатай жинхэнэ уран зохиолын дурсгалыг дав дээр шүүн үзэж, шашны агуулгатай зохиолоос ялган салгаж тавих асуудал зүй ёсоор урган гарч байна.

1. Ц. Дамдинсүрэн, Х. Гаадангийн «Зохист аялгууны толин дахь адилтгал, зүйрлэл» гэдэг ганц сэдэвт зохиолд бичсэн шүүмж, Улаанбаатар 1976-7-16
2. Ш. Бира «БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд» Улаанбаатар, 1977
3. Кочетов А. Н., Буддизм, Москва. 1965
4. Рамстедт Г. И. Уйгур улсын хураангуй түүх. 1922
5. Владимирцов Б. Я. *Mongolica 1. Об отношении монгольского языка к индоевропейским языкам Средней Азии.* ЗКВ., No 1, Ленинград, 1925
6. Дамдин (Зава), *Byang phyogs hor gyi yul du dam pati chos rin po che 'byung tsul gyi gtam rgyud bkra ches chos dung bzhad pa'i sgra dbyangs.*
7. Дамдин. *Dzam glinig byang phyogs chen po horgyi rgyai khams kyi rtogs pa" briodpo' ibstan bcos chen po dnyod ldan mgu byed ngo mtsar gser gyi dab ther* —Лувсандаянгийн сүнбүм. дээрх боть Монгол модон барын хэвлэл. Хуудас 301
8. *ICyal bati bka gyur rin po che zhes gongs su grags pa' klag lung mnos pa'i thob yig bstan pa'i chu gyun skal ldan re bo skong.* Зохиогчийн хувийн цуглуулгад буй бичмэл судар.
9. Махмутов А. Как возник доветюркский алфавит ИТ. Алма-Ата, 1969.
10. *Travels of Fa hsians Trans lated by Dorji Bansaroff.* (CSM, tom. V fasc. 5, Ulan Bator 1970.
11. Д. Дамдинсүрэн, Монгол хэлэнд орсон төвд үг. — Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал, I дэвтэр. (SM, tom, 11, fasc. 1-16). Улаанбаатар, 1961.
12. Рерих Ю. Н. Монголо-Тибетские отношения XIII и XIV вв., Филология и история монгольских народов, Памяти академика В. Я. Владимирцова, Москва, 1968
13. Вострикоз А. И. Тибетская историческая литература. ВВ, XXXII. Москва, 1962.
14. Д Дамдинсүрэн Монголын уран зохиолын тойм Нэгдүгээр дэвтэр, XIII-XIV зууны үе Улаанбаатар, 1957
15. Rinchen Y. *Sanskrit in Mongolia.* --SIAAC, vol. 3, New Delhi. 1973.
16. *bla ma dam pa rnam kyi gsung 'bum kyi drar cheg gnyen 'brel dran gsofi me long.* --SPS. voi. 16, New Delhi, 1961.
17. Монголын уран зохиолын тойм. I дэвтэр (XVII-XVIII зууны үе), Улаанбаатар, 1976
18. Ц. Дамдинсүрэн 14-р зууны үеийн монгол хэл бичгийн эрдэмтэн Чойжи-Одсэр. эх ухааны хүрээлэнгийн бүтээл. Нийгмийн ухааны анги. № 2, Улаан баатар, 1957
19. Т. Пагва Из истории монгольской филологии (Доклады монгольской делегации на XXVI конгрессе востоковедов) Улан-Батор. 1963
20. Владимирцов Б. Я монгольский сборник рассказов из Петерград, 1921
21. Ч.Алтангэрэл, Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл I дэвтэр. Улаанбаатар, 1967 22. С. Гомбожав Монголчуудын төвд хэлээр зохиосон зохиолын зүйл
23. Ролбийдорж (Жанжа) *1Та pa'i gsung mgur.* Жанжан-Ролбийдоржийн сүнбүмийн «На» (Nga) буюу 4-р боть, Бээжин барын хэвлэл, Хуудас 2. УННС-ийн төвд фонд
24. Ишдамбаравжай *1Та pa'i nyams mgur a-ma ngos, 'dzin gyi grel ba bdag dzin dgra dpung 'joms pa'i mtson cha skal lda pad ma bzhad pa'i nyin byed.* Идамбаравжайгийн сүнбүмийн «Ха» (kha) буюу 2-р боть, Төвд модон барын хэвлэл. Хуудас 12, УННС-ийн төвд фонд
25. Гонжигжанцан (Балман цан) *dGag lan bden gtam bdud rtzir 'khyil ba'i snying rje" rol mtso -* Гонжигжанцагийн сүнбүмийн «Ча» (Cha) буюу 6-р боть. Төвд модон барын хэвлэл. Хуудас 108. УННС-ийн төвд фонд
26. Агаанхайдав. *dGag lan me'i "khrul 'khor,* Агванхайдавын сүнбүлийн «Га» (Ga) буюу 3-р боть. Халхын хүрээ барын хэвлэл. Хуудас 41. УННС-ийн төвд фондод
27. Агванхайдав. *bsLab bya sna tsogs kyi skor.* — Агванхайдарын сүнбүм «Га» (Ga) буюу 3-р боть. Халхын хүрээ барын хэвлэл. Хуудас 9. УННС-ийн төвд фондод
28. Агвандамба. *Nyams mgur gyi rim pa rnam phyogs gcig tu bkod pa.* -Агвандамбын сүнбүм. Монголын модон барын хэвлэл. БНМАУ-ын Улсын нийтийн номын сангийн (хойшид УННС гэж товчилно) Төвд фондод.